

Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын
2017 оны... дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт,
тэдгээрийн зэрэглэл

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хог хаягдлын тухай хуулийн 8.1.6 заалтыг үндэслэн эх үүсвэрээс гарах хог хаягдлыг төрөл, шинж чанараар нь ангилалд хамааруулж, аюулын зэрэглэл тогтооход энэхүү жагсаалтыг ашиглана.

1.2. Энэхүү жагсаалтын зорилго нь хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох байгаль орчинд ээлтэй тогтолцоо бий болгох болон хаягдлын үйлчилгээний хураамж тогтоох, мэдээ мэдээлэл гаргахад ашиглахад оршино.

Хоёр. Хог хаягдлыг кодчилох

2.1. Хог хаягдлыг эх үүсвэр, төрлөөр нь ангилж кодчилох ба код нь 6 цифрээс бүрнэ.

2.2. Эхний 2 цифр нь хог хаягдлын бүлгийг тэмдэглэнэ. Жишээ нь: 13 - Хаягдал тос ба шингэн түлш.

2.3. Дараагийн 2 цифр нь хог хаягдлын дэд бүлгийг заана. Жишээ нь: 13 01 - Гидравлик тосны хаягдал.

2.4. Сүүлийн 2 цифр нь тухайн дэд бүлгээс үүсэх хог хаягдлын төрлийг заана. Жишээ нь: 13 01 04- Хлор агуулсан эрдсийн гидравлик тос.

2.5. “99”-ээр төгссөн кодтой “Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал”-д тухайн дэд бүлгийн жагсаалт болон 13, 14, 15, 16 дугаар бүлгийн жагсаалтад ороогүй бусад хог хаягдал орно.

Гурав. Хог хаягдлын аюулын зэрэглэл

3.1. Хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх аюулын шинж чанараар нь “аюултай”, “хяналттай” болон “энгийн” гэж зэрэглэнэ.

3.2. Хог хаягдал нь 1 дүгээр хүснэгтэд заасан аюулын шинж чанараас нэг болон хэд хэдэн шинж чанарыг зэрэг агуулж байвал аюултай хог хаягдал гэж үзнэ.

1-р хүснэгт. Аюулын шинж чанар

НҮБ-ын анги-лал	Аюу-лын код	Шинж чанар	Тайлбар
1	H1	Тэсрэмтгий	Орчны юмсыг гэмтээх хэмжээний хурд, даралт, температур бүхий хий ялгаруулдаг химийн урвалд өөрөө орох

			чадвар бүхий хатуу, шингэн бодис, хаягдал (эсвэл бодис, хаягдлын хольц)
3	Н3	Шатамхай (шингэн)	Битүү саванд 60,5°C, задгай саванд 65,6°C-аас ихгүй температурт шатамхай уур ялгаруулдаг шингэн, шингэний хольц, суспенз
4.1	Н4.1	Шатамхай (хатуу)	Тээвэрлэлтийн явцад амархан шатдаг эсвэл үрэлтийн улмаас өөрөө шатдаг, тэсрэмтгий бодисын ангилалд хамаардаггүй хатуу бодис, тэдгээрийн хаягдал
4.2	Н4.2	Өөрөө идэвхжиж шатдаг	Тээвэрлэлтийн явцад хэвийн нөхцөлд аяндаа халснаас эсвэл агаартай харилцан үйлчилж халалт үүснээс гал авалцдаг бодис, хаягдал
4.3	Н4.3	Норвол шатамхай хий ялгаруулдаг	Устай харилцан үйлчилснээс аяндаа шатдаг эсвэл шатамхай хийг аюултай хэмжээгээр ялгаруулдаг бодис, хаягдал
5.1	Н5.1	Исэлдүүлэгч	Өөрөө шатамхай шинж чанартай биш боловч ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулж бусад материалын шаталтыг тэтгэдэг бодис, хаягдал
5.2	Н5.2	Органик хэт исэл	Хоёр валенттай -0-0- гэсэн бүлэг агуулсан, дулаанд тогтвортой биш, дулаан ялгаруулж өөрөө задардаг бодис, хаягдал.
6.1	Н6.1	Онцгой хортой	Амьсгалах, залгих, арьс салтаар хүрэлцэх замаар хүний биед ороход хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлдэг, үхэлд хүргэх аюултай бодис, хаягдал
6.2	Н6.2	Халдвартай	Хүн болон амьтныг өвчлүүлдэг нь тогтоогдсон эсвэл өвчлүүлэх чадвартай бичил биет болон микробын хор агуулсан бодис, хаягдал
8	Н8	Идэмхий	Химийн урвалын нөлөөгөөр амьд организмын эд эрхтэнтэй шууд хүрэлцэхэд ноцтой гэмтэл учруулдаг эсвэл асгарсан алдагдсан үед бусад эд материал болон тээврийн хэрэгсэлд гэмтэл, эвдрэл үзүүлдэг бодис, хаягдал
9	Н.10	Агаар эсвэл устай харилцан үйлчлэхэд хортой хий ялгаруулдаг	Агаар эсвэл устай харилцан үйлчилснээс хортой хийг аюултай хэмжээгээр ялгаруулдаг бодис, хаягдал
9	Н11	Архаг хордлого өгдөг (хорт хавдар үүсгэдэг)	Амьсгалах, залгих, арьс салтаар хүрэлцэхэд урт хугацаанд архаг хордлого өгдөг, хорт хавдар үүсгэдэг, үр удамд нөлөөлдөг бодис, хаягдал

9	H12	Байгаль орчинд хортой	Биотод хортой нөлөө үзүүлэх, био хуримтлал үүсгэх замаар хүрээлэн буй орчинд түргэн болон урт хугацааны нөлөөлөл үзүүлдэг бодис, хаягдал
9	H13	Устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг	Устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг бодис, хаягдал. Жишээ нь: аюултай шинж чанартай шүүрэл

3.2. Аюултай хог хаягдлыг “А” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэх бөгөөд ийм тэмдэглэгээтэй хог хаягдлыг шууд аюултай хог хаягдал гэж үзнэ.

3.3. “Хяналттай” хог хаягдлыг “Х” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэх бөгөөд ийм хог хаягдал нь 2 дугаар хүснэгтэд заасан аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг 3 дугаар хүснэгтэд заасан босго түвшинтэй тэнцүү болон түүнээс их хэмжээгээр агуулж байвал “аюултай” хог хаягдал гэж үзнэ.

3.4. “Хяналттай” хог хаягдал нь аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшингээс бага хэмжээгээр агуулж байвал “энгийн” хог хаягдал гэж үзнэ.

Хүснэгт 2. Хог хаягдлын аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүн

Код	Аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүн хэсэг
C1	Бериллий, түүний нэгдлүүд
C2	Ванадийн нэгдлүүд
C3	6 валенттай хромын нэгдлүүд
C4	Кобальтын нэгдлүүд
C5	Никелийн нэгдлүүд
C6	Зэсийн нэгдлүүд
C7	Цайрын нэгдлүүд
C8	Хүнцэл, түүний нэгдлүүд
C9	Селен, түүний нэгдлүүд
C10	Мөнгөний нэгдлүүд
C11	Кадьмий, түүний нэгдлүүд
C12	Цагаан тугалгын нэгдлүүд
C13	Сурьма, түүний нэгдлүүд
C14	Теллур, түүний нэгдлүүд
C15	Барийн нэгдлүүд (барийн сульфат орохгүй)
C16	Мөнгөн ус, түүний нэгдлүүд
C17	Таллий, түүний нэгдлүүд
C18	Хар тугалга, түүний нэгдлүүд
C19	Органик бус сульфидууд
C20	Органик бус фторт нэгдлүүд (кальцийн фторид орохгүй)
C21	Органик бус цианидууд
C22	Шүлтийн болон газрын шүлтийн металлууд (нийлмэл биш хэлбэртэй лити, натри, кали, кальци, магни)
C23	Хүчиллэг уусмалууд ба хатуу төлөвтэй хүчлүүд
C24	Шүлтлэг уусмалууд ба хатуу төлөвтэй шүлтүүд
C25	Асбест (нунтаг, утаслаг)

C26	Фосфор, түүний нэгдлүүд (эрдсийн фосфатууд орохгүй)
C27	Металл карбонилууд
C28	Хэт ислүүд
C29	Хлоратууд
C30	Перхлоратууд
C31	Азидууд
C32	Полихлорт бифенил (PCBs) болон полихлорт терфенил (PCTs)
C33	Эмийн болон малын эмийн бодисууд
C34	Биоцидууд ба ургамлын гаралтай эмийн бодисууд (жишээ нь, пестицидүүд)
C35	Халдвартай бодисууд
C36	Креосотууд
C37	Изоцианидууд, тиоцианатууд
C38	Органик цианидууд
C39	Фенолууд, тэдгээрийн нэгдлүүд
C40	Галогент уусгагчид
C41	Органик уусгагчид (галогент уусгагчдаас бусад)
C42	Галогент органик нэгдлүүд (идэвхгүй полимер материал болон энэ хүснэгтэд дурьдсан бусад бодис хамаарахгүй)
C43	Ароматик нэгдлүүд, олон цагирагт болон гетероцагирагт нэгдлүүд
C44	Алифатик аминууд
C45	Ароматик аминууд
C46	Эфирүүд
C47	Тэсрэмтгий шинж чанартай бодисууд, (энэ хүснэгтэд дурдсан бусад бодис хамаарахгүй)
C48	Хүхэрт органик нэгдлүүд
C49	Полихлорт дибензо-фураны изомерүүд
C50	Полихлорт дибензо-п-диоксины изомерүүд
C51	Нүүрсустөрөгчид ба тэдгээрийн ислүүд, энэ хүснэгтэд ороогүй азот болон хүхэрт нэгдлүүд

Аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүний босго түвшин

3-р хүснэгт

Химийн хорт болон аюултай бодис	Босго түвшин
Шатамхай (гал авалцах температур °C)	≤55
Хортой бодис (A, B зэрэглэл), %	≥ 0,1
Хортой бодис (C, D зэрэглэл), %	≥ 3,0
Хортой бодис (E зэрэглэл), %	≥ 25,0
Идэмхий бодис (A зэрэглэл), %	≥ 1,0
Идэмхий бодис (B зэрэглэл), %	≥ 5,0
Идэмхий бодис (C зэрэглэл), %	≥ 10,0
Хавдар үүсгэгч (A, B зэрэглэл), %	≥ 0,1
Үр удамд нөлөөлөгч (A зэрэглэл), %	≥ 0,1
Үр удамд нөлөөлөгч (B зэрэглэл), %	≥ 1,0
Нөхөн үржихүй/өсөлт хөгжилтөнд нөлөөлөгч (A зэрэглэл), %	≥ 0,5
Нөхөн үржихүй/ өсөлт хөгжилтөнд нөлөөлөгч (B зэрэглэл), %	≥ 5,0

3.5. Хүснэгт 3-т заасан аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг зэрэглэлд хамааруулахад химийн хорт болон аюултай бодисын ангиллыг мөрдөнө.

3.6. “Аюултай” болон “Хяналттай” хог хаягдлын код нь “*” гэсэн тэмдэглэгээтэй байна.

Жишээ нь: 13 01 04* Тосны шүүлтүүр А

08 03 03* Хортой бодис агуулсан хэвлэлийн будагны хаягдал Х